

СУРГАГЧ БАГШ

БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР

Talented Development

Байгууллагад тулгарч байгаа бодит асуудлыг зөв тодорхойлж, түүнийг шийдвэрлэх арга замыг сонгоход байгууллагын нөөцийг хэрхэн дайчлах вэ гэдэг нь чухал асуудал билээ. Ихэнх байгууллагын удирдлагууд сургалтын хэрэгцээгээ бодитой судлалгүй, үйл ажиллагааны онцлогоо харгалзалгүй сургалт зохион байгуулж мөнгө, цаг хугацаа алддаг. Тэгвэл бидний эрчимжүүлсэн сургалт нь:

ТЭГВЭЛ БИДНИЙ ЭРЧИМЖҮҮЛСЭН СУРГАЛТ НЬ:



•Онол - практик хосолсон үр дүнтэй сургалтын загвар боловсруулсан Карен Лоусон, Дональд Киркпатрик нарын хөтөлбөрөөр явагдана.

•Сургалтыг олон жил багшилсан мэргэшсэн сургагч багш нар чиглүүлнэ.

•Сургалтын хэрэгцээг тодорхойлохоос эхлэн үр дүнг үнэлэх хүртэл бүх шатны алгоритмыг боловсруулж өгнө.

СЭДЭВ 1

СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

/Training style/



ТОВЧ: Байгууллагынхаа сургалтын хэрэгцээг яаж тодорхойлох вэ?, ямар аргуудыг хэрэглэх вэ?, цуглуулсан мэдээлэлдээ хэрхэн дүн шинжилгээ хийх вэ?, хэрэгцээнд тулгуурласан, прагматик сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулдаг вэ? Сургалтаас өмнөх мэдлэг, чадвар хандлагыг хэрхэн үнэн зөв тодорхойлох вэ?

Мэдлэг, мэдээлэл, ур чадвар, хандлагыг хэрхэн эзэмшдэг вэ?, хүмүүс яаж суралцдаг вэ?, үр дүнтэй суралцах арга барилууд, хүнийг сургах үндсэн зарчмуудад юу вэ? Эдгээрийг харгалзаж хэрхэн сургах вэ гэдэг талаар мэдлэг эзэмшиж сургалтуудад хэрэглэх чадвартай болно.

ДАСГАЛ: Өөрийн байгууллагын сургалтын хэрэгцээ, сургалтын хөтөлбөрийг боловсруулна. Суралцах хэв маяг тодорхойлох тест,

СЭДЭВ 3

ПРЕСЕНТЭЙШН БЭЛТГЭХ АРГА ЗҮЙ?

/Creating a PPT/



ТОВЧ: Бэлтгэсэн хичээлийн агуулгаа суралцагсдад цэгцтэй, шинэлэг, бүтээлчээр хүргэхэд туслах үзүүлэх материалыг бэлтгэх арга барилд суралцана.

ДАСГАЛ: Багшийн удирдлага дор оролцогч тус бүр сонгосон сэдвийн дагуу PPT бэлтгэнэ.

СЭДЭВ 2

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГЫГ ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

/Creating a design matrix/



ТОВЧ: Хичээлийн конспект, агуулгыг ямар бүтцээр зохион байгуулах нь үр дүнтэй байдаг вэ?, үр дүнтэй сургалтын агуулгыг бэлтгэх үндсэн загварууд, агуулгын матриц боловсруулалт, агуулга хөгжүүлэлт хийхэд суралцана.

ДАСГАЛ: Багшийн удирдлага дор оролцогч тус бүр нэг сэдэв сонгож хичээлийн агуулгын матриц, дизайн, хөгжүүлэлт хийнэ

СЭДЭВ 4

ДАДЛАГА

/WORKSHOP/



ТОВЧ: Бэлтгэсэн хичээлийн PPT-ээ танилуулнах

ДАСГАЛ: Суралцагс тус бүрт хичээлийн агуулгын зөвлөгөөг өгнө

СЭДЭВ 5

СУРГАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХҮРГЭХ АРГАЗҮЙ?

/Creating a PPT/

ТОВЧ: Сургагч багш өөрийн сэтгэл зүйн онцлогтоо тохирох багшлах хэв маягаа танин мэднэ. Үүндээ тохирсон үр дүнтэй сургалтын аргуудыг хэрхэн хэрэглэх, сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад биеийн хэл, дуу хоолойгоо үр дүнтэй удирдаж өөрийн санаа бодлоо ойлгуулж, танхимтай харилцах чадварт суралцана.

ДАСГАЛ: Багшийн хэв шинж тус бүрээр богино хугацааны үзүүлэх хичээл зохион байгуулах. Оролцогч тус бүр богино хэмжээний илтгэл танилцуулж өөрт тохирсон зөвлөгөө, даалгаврыг авна.

СЭДЭВ 7

СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ

/Evaluating training/

ТОВЧ: Сургалтын үр дүнг үнэлэх үндсэн арга, шатлал, хэзээ, хэн, юуг, хэрхэн үнэлэх вэ?, сургалтад дутагдсан, сайжруулах шаардлагатай элементүүдийг хэрхэн тодруулах вэ?, суралцагчийн эсвэл сургагчийн зүгээс сургалтын үр дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг хэрхэн тодруулах вэ?, сургалтын үнэлгээний тайланг хэрхэн бичих арга зүйд тус тус суралцсан байна.

ДАСГАЛ: Сургалтын эцсийн үр дүнг суралцагчидтай хамтран дүгнэх.

СЭДЭВ 6

ИДЭВХИТЭЙ СУРГАЛТЫН АРГУУДЫГ СОНГОХ, ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ, ХӨГЖҮҮЛЭХ

/Selecting, designing and developing active-training methods/



ТОВЧ: Идэвхигүй сурах, идэвхитэй суралцахын ялгаа. Идэвхитэй суралцахад татан оролцуулах аргууд, оролцооны сургалтыг зохион байгуулах аргууд, ажлын байрны бодит орчин/туршлагад тулгуурлан суралцах аргуудын талаар мэдлэгтэй болж бодит үйл ажиллагаанд хэрэглэх чадвартай болно.

ДАСГАЛ: Оролцогч бүр нэг арга сонгон бусаддаа богино хугацааны хичээл заах.

ХӨТӨЛБӨР



модуль 1 / Ур Чадвар /

СУРГАЛТЫН АРГАЗҮЙ

АГУУЛГА

- Хүмүүс хэрхэн суралцдаг вэ?
- Сургалтын хэрэгцээг тодорхойлон, хөтөлбөр боловсруулах
- Суралцагсдын онцлогт тохируулан сургалтын үр нөлөөг дээшлүүлэх аргууд



модуль 2 / Ур Чадвар /

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГЫГ БЭЛТГЭХ МАТРИЦ

АГУУЛГА

- Хичээлийн агуулгын үндсэн дизайн
- Сургалтын агуулга боловсруулах
- Агуулга хөгжүүлэлт



Модуль 3 / Ур Чадвар /

ПРЕСЕНТЭЙШН БЭЛДЭХ АРГАЗҮЙ

АГУУЛГА

- Template бүтээх
- Зураг, дүрс, видеог бүтээлчээр ашиглах
- Диаграм, график бүтээх чадвар
- Өнгө тохируулах чадвар
- Анимэйшн бүтээх чадвар



Модуль 4 / Ур Чадвар /

ДАДЛАГА

АГУУЛГА

- Бэлтгэсэн хичээлээ танилцуулах дадлага



Модуль 5 / Ур Чадвар /

СУРГАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХҮРГЭХ АРГАЗҮЙ

АГУУЛГА

- Сургагч багшийн хэв маягаа тодорхойлох
- Толилуулах ур чадвар
- Биеийн хэл, дуу хоолойг үр дүнтэй удирдах



Модуль 6 / Ур Чадвар /

ИДЭВХИТЭЙ СУРГАЛТЫН АРГУУДЫГ СОНГОХ, ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ, ХӨГЖҮҮЛЭХ

АГУУЛГА

- Идэвхитэй сургалтын аргууд
- Хамтран суралцах аргууд
- Идэвхитэй сургалтын орчин бүрдүүлэх аргууд









Модуль 7 / Ур Чадвар /

СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ

АГУУЛГА

- Хэзээ, хэн, юуг, яаж үнэлэх вэ?
- Үнэлгээний 4 шатлалт загвар
- Үнэлгээний тайлан бичих арга зүй
- Төгсөлтийн тэмцээн

A decorative geometric pattern consisting of a repeating grid of white triangles and lines on a dark blue background, located at the bottom of the page.

 www.mlctraining.mn  info@mlctraining.mn
 7010 1839, 99049075  fb.com/mlctraining
 Залуучууд зочид буудлын Д корпус, 4 давхар
Бага Тойруу-4, 14200, 6-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс